



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**Чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос ТӨГТООХ нь:

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар 1992 оны Үндсэн хууль дагаж мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрууд, тэдгээрийн ажилтнууд нэр холбогдсон хар тамхи болон бусад хэрэг зөрчлийн талаарх Гадаад харилцааны сайдын мэдээллийг сонсоод Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, төрийн холбогдох байгууллагад чиглэл болгосугай:

1/Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т:

а/2019 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 70 кг мансууруулах бодис тээвэрлэж яваад Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Дрезден хотод саатуулагдсан гэмт хэрэгтэй холбоотой зохих албан тушаалтнуудад хариуцлага тооцох, дипломат албанд томилогдон ажиллах албан тушаалтныг хариуцлагажуулах, олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж зөрчсен, Монгол Улсын нэр хүндэд сергөөр нөлөөлсөн үйлдэл, үйл ажиллагаа явуулсан албан тушаалтныг нэн даруй эгүүлэн татах, дахин дипломат албанд томилохгүй байх, гэм буруутай үйлдэлд нь хариуцлага хүлээлгэж байх;

б/Дипломат төлөөлөгчийн газар ажиллах хугацаандаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тамхи тээвэрлэх болон бусад хууль бус үйлдэл, хэрэг, зөрчилд холбогдож байсан боловч төрийн албанд үргэлжлүүлэн ажиллаж буй албан тушаалтнуудыг шалган тогтоож, төрийн албанаас нэн даруй чөлөөлөх;

в/mansuuuruuulaah эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх хууль эрх зүйн орчныг судлан шаардлагатай бол энэ төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх ялын бодлогыг чангатгах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих эрх зүйн орчныг сайжруулах саналыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

г/mansuuuruuulaah эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох байгууллага болон холбогдох бусад байгууллагын хүн хүч, техникийг бэхжүүлэх, шаардлагатай бол уг гэмт хэрэгтэй тэмцэх бие даасан байгууллага байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх.

2/Гадаад харилцааны яам /Д.Цогтбаатар/-нд:

а/Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой хамтарч Гадаад харилцааны яамны нийт ажилтан, албан хаагчдын томилогдсон шийдвэр, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, шаардлага хангаагүй албан тушаалтныг чөлөөлөх, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд тавих Гадаад харилцааны яамны хяналтыг чангатгах, дотоод аудитын үйл ажиллагааг чанааржуулах, хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах;

б/Монгол Улсын тухайн улстай харилцаах харилцааны түвшинг харгалзан Дипломат төлөөлөгчийн газарт ажиллах байгууллагын төлөөллийн зохистой харьцаанд хяналт тавьж, мөрдөх;

в/Дипломат албаны тухай хуульд заасан дипломат албан тушаал эрхлэх болзлыг чанд мөрдүүлэх, дипломат албандаа ажиллах хүнийг сонгон шалгаруулахдаа хувь хүний талаас нь сайтар судлах, дипломат албандаа тодорхой мэргэжлийн териин албан хаагчийг ажиллуулахад баримтлах шалгуурыг өндөрсгөх, энэ талаар тогтоосон журмыг мөрдөх, шаардлагатай бол шинэчлэн батлах;

г/mansuuruulaah эм, сэтгэцэд нөлөөт бодис, тамхи тээвэрлэх болон бусад хууль бус үйлдэл, хэрэг, зөрчилд нэр холбогдсон боловч одоо Дипломат төлөөлөгчийн газар ажиллаж байгаа албан тушаалнуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эгүүлэн татах, хариуцлага хүлээлгэх;

д/дипломат болон албан паспорт ашиглалт, шилжилт хөдөлгөөн, дипломат дугаартай тээврийн хэрэгсэл, тэдгээрийн ашиглалтын бүртгэл, хяналтыг сайжруулах;

е/Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын албан хаагчид болон Монгол Улсын иргэдийг тухайн улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль тогтоомжийн талаарх мэдээллээр хангах, энэ төрлийн хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг зохион байгуулах.

### 3/Тагнуулын ерөнхий газар /Д.Гэрэл/-т:

а/Хүн амын аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг чангатгах.

### 4/Цагдаагийн ерөнхий газар /С.Баатаржав/-т:

а/Хар тамхитай тэмцэх газрын хүний нөөцийг бэхжүүлэх, техник, тоног төхөөрөмжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах;

б/иргэдийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагаврын талаарх мэдээллээр хангах, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдох, ашиглагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сээрэмжлүүлэх, таниулах арга хэмжээг зохион байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн

газар /У.Хүрэлсүх/, Гадаад харилцааны яам /Д.Цогтбаатар/, Тагнуулын ерөнхий газар /Д.Гэрэл/, Цагдаагийн ерөнхий газар /С.Баатаржав/-т тус тус даалгасугай.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, РАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Т.АЮУРСАЙХАН

УХА0318

М.А.